



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР 2018 ОНД  
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

/2018 оны I улирлын байдлаар/

2018.04.13

**Нэг. Танилцуулга**

ЗТХЯ нь 2018 онд Засгийн газрын хуралдаанаар нийт 35 асуудал хэлэлцүүлэхээр төлөвлөж, саналаа ЗГХЭГ-т хүргүүлэн сайдын 2018.01.10-ны өдрийн 07 дугаар тушаалаар батлуулсан байна.

2018 оны төлөвлөгөөнд ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тусгагдсан асуудлын тоог газар, хэлтсээр нь авч үзвэл (давхардсан тоогоор):

№	Хариуцах газар, хэлтэс	Улирал				Нийт	
		I	II	III	IV	нийт	Үүнээс толгойлон
1	БТГ	12	14	6	6	34	16
2	ТЗУГ	1	4	3	-	4	-
3	ТЗДТБХЗГ	1	3	1	1	4	3
4	АТБХЗГ	4	5	2	2	12	10
5	АЗБХЗГ	-	1	1	-	2	2
6	АТБХЗХ	8	5	2	3	17	5
<b>Нийт</b>		<b>13</b>	<b>14</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>35</b>	

Төлөвлөгөөний хэрэгжилтэд 2018 оны I улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үзэхэд Засгийн газрын хуралдаанаар I улиралд хэлэлцүүлэхээр төлөвлөсөн 13 асуудлын хэрэгжилтийн байдал:

№	Хариуцах газар, хэлтэс	Төлөвлөсөн	Хэлэлцүүлсэн	Хугацаа наас өмнө	Шаардлагагүй болсон	Хэлэлцүүлээгүй			Хувь
						70%	30%	0%	
1	БТГ	12	4	1	1	-	7	-	59,2
3	ТЗУГ	1	-	-	-	-	1	-	30,0
4	ТЗДТБХЗГ	1	-	-	-	-	1	-	30,0
5	АТБХЗГ	4	2	-	1	-	1	-	76,7
6	АТБХЗХ	8	3	1	-	-	5	-	61,1
<b>Нийт</b>		<b>13</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>7</b>	<b>-</b>	<b>62,3</b>

## Хоёр. Үнэлэлт, дүгнэлт

### 1. Төлөвлөлтийн байдал:

1) 2017 оны төлөвлөгөөнд тусгаад хэлэлцүүлээгүй үлдсэн 15 асуудлаас 2018 оны төлөвлөгөөнд 14 асуудлыг тусгаж, 1 асуудлыг тусгаагүй хассан бөгөөд энэ нь төлөвлөгөөнд тусгах шаардлагагүй асуудал байна.

2) 2017 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн дагуу 2018 онд ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг тухайн оны 1 дүгээр сард багтаан 2018.01.10-ны өдрийн ЗТХСайдын тушаалаар батлуулсан байна.

### 2. Хэрэгжилтийн байдал:

1) 2017 оны I улиралд ЗГ-ийн хуралдаанд хэлэлцүүлэхээр төлөвлөсөн 13 асуудлаас 6 асуудлыг ЗГХЭГ-т хүргүүлэн 4 асуудал хуралдаанаар хэлэлцэгдэж дэмжигдсэн, 1 асуудлыг ЗГХ-аар хэлэлцүүлэх шаардлагагүй болсон байна. Төлөвлөсөн 7 асуудал боловсруулалтын шатанд 30%-ийн хэрэгжилттэй байгаа бөгөөд II улиралд төлөвлөсөн 1 асуудлыг хугацаанаас өмнө ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 62,3%-тай байна.

2) “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөл байгуулах” талаар ЗГХЭГ-т 2 удаа албан бичиг хүргүүлсэн боловч ЗГХЭГ-ээс Үндэсний зөвлөл байгуулахгүйгээр Зам, тээврийн хөгжлийн сайд ахалсан Үндэсний хороог үргэлжлүүлэн ажиллуулах чиглэл өгсөн, “БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2 дугаар шатны тухай” асуудлыг БНСУ-ын ЭКСИМ банкнаас 2017 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн MON-11/17-133 тоот албан бичгээр хэлэлцээр, гэрээнд өөрчлөлт оруулах боломжгүй тухай татгалзсан хариуг ирүүлсэн тул ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагагүй болсон гэж үзэж хяналтаас хаслаа.

3) ЗГХ-аар 2018 оны I улиралд хэлэлцүүлэхээр төлөвлөсөн дараах 7 асуудал хугацаа хоцорсон, удаашралтай байна. Үүнд:

- Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл
- “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын статусыг өөрчлөн зохион байгуулах тухай
- Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Камбожийн Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах тухай
- Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах тухай
- Дэлхийн худалдааны байгууллагын олон талт худалдааны хэлэлцээрийн “Иргэний агаарын хөлөг худалдах тухай хэлэлцээр”-т нэгдэн орох тухай УИХ-ын тогтоолын төсөл
- “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр” батлах тухай
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийн тухай

4) 2018 оны II улиралд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр төлөвлөсөн 14 асуудлаас 1 асуудлыг хэлэлцүүлэн дэмжүүлсэн, 1 асуудлыг хяналтаас хассан бөгөөд “Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл”, “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын

менежмент төслийг хэрэгжүүлэх концесс олгох тухай” асуудлаас бусад 10 асуудал мөн хэрэгжилтийн явц удаашралтай, төлөвлөгөө хэрэгжихгүй байх магадлалтай байна.

### Гурав. Санал, зөвлөмж

1) ЗТХС-ын тушаалаар батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх талаар газар, хэлтсийн дарга нар онцгой анхаарч ажиллах, ялангуяа I, II улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх төлөвлөгөөтэй салбарын 4 хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөл, Төрөөс баримтлах 2 бодлогыг боловсруулж дуусган яамдаас санал авах ажлыг түргэтгэх;

2) Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг газар, хэлтсийн дарга нар тухайн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн Үр дүнгийн гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийн нэг болгож ажиллах;

Танилцсан:	
Сайд	Ж.Бат-Эрдэнэ
Төрийн нарийн бичгийн дарга	Ж.Бат-Эрдэнэ
Төрийн захиргааны удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Махбал
Бодлого төлөвлөлтийн газрын дарга	Р.Мэргэн
Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Д.Доржханд
Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	С.Батболд
Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Б.Артур
Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга	С.Мөнхнасан
Хянасан:	
ХШҮДАГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Т.Гомбосүрэн
Боловсруулсан:	
ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн	Д.Баярмаа